



ДУНДГОВЬ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН  
ДАРГЫН ТУШААЛ

2022 оны 06 сарын 00 өдөр

Дугаар 4/155

Мандалговь

Ажлын хэсэг томилох тухай

Төрийн болон албаны нууцын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.1.3 Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.2.5, Засгийн газрын 2017 оны 246 дугаар тогтоолын 1, 2 дугаар хавсралт, Батлан хамгаалахын сайдын 2019 оны н/19 дүгээр тушаалаар батлагдсан “Монгол Улсын батлан хамгаалахын төрийн болон албаны нууцыг хамгаалах журам”-ын 2.1.4, 2.1.9 дэхь заалтуудыг үндэслэн ТУШААХ нь:

1. Аймгийн улсын дайчилгааны асуудлыг хариуцсан мэргэжилтэнд хамарагдаж буй ажил, маш нууц, нууц бичгийн хадгалалт, хамгаалалтын талаар үзлэг, шалган туслах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй томилсугай.

Комиссын дарга: Ш.Гансүх (Цэргийн штабын дарга, дэд хурандаа)

Гишүүдэд: Г.Цэрэндолгор (Цэргийн штабын тоо бүртгэлийн офицер, дэд хурандаа)

Д.Даариймаа (Хяналт, Шинжилгээ үнэлгээний хэлтсийн хэтийн зорилт, үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийн хяналт шинжилгээ, үнэлгээ хариуцсан мэргэжилтэн)

2. Улсын дайчилгааны асуудлыг хариуцсан мэргэжилтэнд хадгалагдаж буй төрийн нууцтай холбоотой баримт бичиг болон бусад нууц тээгчийн ашиглалт, хадгалалт, хамгаалалт, бүрэн бүтэн байдалд 2022 оны 06 дугаар сарын 20-ноос 21-ний хооронд үзэж тоолон, шалган туслах ажлыг хийж цаашид авах арга хэмжээний талаарх санал, дүгнэлтийг тусгаж акт үйлдэн холбогдох байгууллагад нь хүргүүлэхийг ажлын хэсгийн дарга (дэд хурандаа Ш.Гансүх)-д үүрэг болгосугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ  
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

И.Доржбат

Л.ДОРЖБАТ

4822150368